

Тамга

Археологичид эртний Хүннү хэлээр бичсэн дугуй тамга олжээ. Тамган дээр S гэсэн тэмдэгт мөрийг төгсгөлийнх нь араас эхлэл нь залгагдсан байдлаар дүрсэлсэн.

Тэд тамган дотроос W үгийг хайж байгаа ба тэр нь g үсгээс тогтоно.

Хүннү хэлний гол онцлог нь үгэн дотор байгаа үсэгнүүд чөлөөтэйгээр байраа сольж болдогт оршино.

Тэдэнд W үг тамганд хэдэн удаа орсныг тооцоолох програм бич.

Хязгаарлалт

$1 \leq g \leq 3000$ W үгийн урт

$g \leq |S| \leq 3000000$ S тэмдэгт мөрийн урт

Оролт

Эхний мөрөнд g болон $|S|$ -ийг илэрхийлэх хоёр бүхэл тоо байна.

Хоёр дахь мөрөнд g тэмдэгтээс тогтох W үг байрлана. Тэмдэгтүүд нь англи цагаан толгойн том болон жижиг үсгүүд байж болох ба том, жижиг үсгийг ялгаатайд тооцно.

Гурав дахь мөрөнд тамган дээр байгаа S тэмдэгт мөр байрлана. Тэмдэгтүүд нь англи цагаан толгойн том болон жижиг үсгүүд байж болох ба том, жижиг үсгийг ялгаатайд тооцно.

Гаралт

S тэмдэгт мөрөнд W үг хэдэн удаа орсныг харуулах бүхэл тоог гаргана.

Жишээ оролт

4 11

cZdf

ZbRfZbrZcfd

Жишээ гаралт

2